



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/147

Алтанбулаг

Согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэхийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/390 тоот “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд цэрэг татлага зохион байгуулагдаж байгаа учир суманд 2022 оны 10 дугаар сарын 15, 19-ний өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал), Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Г.Энхтүвшин), ХАА тасгийн мэргэжилтэн (Б.Отгонбилэг) нарт даалгасугай.



Н.ОТГОНЦОГТ